

**ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
ҮНИЙН 20 ... ОНЫ ... САРЫН МЭДЭЭ**

	нэр	код
Аймаг, нийслэл		
Сум, дүүрэг		
Баг, хороо		

1. Сумын засаг даргын орлогч, дүүргийн статистикийн хэлтсээс сар бүрийн 2-ны дотор нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтэст;

2. Аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтсээс ҮСХ-нд сар бүрийн 4-ны дотор цахим шуудангаар ирүүлнэ.

1. Малын үнэ

		Мөрийн дугаар	Нэг толгойн үнэ (төгрөг)			Мөрийн дугаар	Нэг толгойн үнэ (төгрөг)
А		Б	1	А		Б	1
1.1 Тэмээ				1.4 Хонь			
Буур		1		Хуц		22	
Нас гүйцсэн	Нас гүйцсэн ат	2		Нас гүйцсэн	Эр хонь	23	
	Нас гүйцсэн ингэ	3			Эм хонь	24	
Өсвөр	Эр шилбэ	4		Өсвөр	Эр төлөг	25	
	Эм шилбэ	5			Эм төлөг	26	
Төл	Эр ботго	6		Төл	Эр хурга	27	
	Эм ботго	7			Эм хурга	28	
1.2 Адуу				1.5 Ямаа			
Азарга		8		Ухна		29	
Нас гүйцсэн	Соёолон үрээ	9		Нас гүйцсэн	Эр ямаа	30	
	Соёолон гүү	10			Эм ямаа	31	
Өсвөр	Шүдлэн үрээ	11		Өсвөр	Эр борлон	32	
	Шүдлэн байдас	12			Эм борлон	33	
Төл	Эр унага	13		Төл	Эр ишиг	34	
	Эм унага	14			Эм ишиг	35	
1.3 Үхэр				2. Тэжээвэр амьтдын үнэ			
				2.1 Гахай			
Бух		15		Бодон		1	
				Мэгж		2	
Нас гүйцсэн	Хязаалан шар	16		Торой		3	
	Хязаалан дөнж	17		2.2 Шувуу болон бусад амьтад			
Өсвөр	Шүдлэн эр үхэр	18		Тахиа		4	
				Галуу		5	
	Шүдлэн гунж	19		Үнэг		6	
Төл	Эр тугал	20		Илжиг		7	
				Цаа буга		8	
	Эм тугал	21		Туулай		9	
				Зөгий, бүл		10	

3. Малын гаралтай бүтээгдэхүүний үнэ

	Мөрийн дугаар	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ (төгрөг)		Мөрийн дугаар	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ (төгрөг)
А	Б	В	1	А	Б	В	1
3.1 Мах				3.4 Хөөвөр, хялгас			
Тэмээний	1	кг		Адууны хөөвөр	13	кг	
				Үхрийн хөөвөр	14	кг	
Гахайн	2	кг		Адууны хялгас			
				Адууны дэл	15	кг	
Тахианы	3	кг		Адууны сүүл	16	кг	
3.2 Сүү				Үхрийн хялгас	17	кг	
Ингэний	4	л		3.5 Арьс, шир			
Гүүний	5	л		Тэмээний шир	18	ш	
Богийн сүү	6	л		Адууны шир	19	ш	
3.3 Ноос, ноолуур, хөөвөр, хялгас				Үхрийн шир			
3.3.1 Тэмээний ноос				1.8-2.3 метрийн хэмжээтэй шир	20	ш	
Эр ноос	7	кг		2.3 метрээс дээш хэмжээтэй шир	21	ш	
Эм ноос	8	кг		Хонины ноостой нэхий	22	ш	
3.3.2 Ямааны ноолуур				Хонины ноосгүй нэхий	23	ш	
Цагаан ноолуур	9	кг		Хурганы арьс	24	ш	
Бор ноолуур	10	кг		Каракуль хурганы арьс	25	ш	
Хялгастай ноолуур	11	кг		Ямааны ноолууртай арьс	26	ш	
3.3.3 Хонины ноос				Ямааны ноолуургүй арьс	27	ш	
Хонины ноос	12	кг		Ишигний арьс	28	ш	

4. Газар тариалангийн бүтээгдэхүүний үнэ

	Мөрийн дугаар	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ (төгрөг)		Мөрийн дугаар	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ (төгрөг)
А	Б	В	1	А	Б	В	1
4.1 Үр тариа				4.4 Техникийн ургамал			
Буудай				Наранцэцэг	16	т	
Үрийн буудай	1	т		Чихрийн манжин	17	т	
Таваарын буудай	2	т		Тосны ургамал, рапс	18	т	
Арвай	3	т		Бэлтгэсэн өвс (хадлан)			
Овьёос	4	т		Боодолтой өвс, 25 кг	19	боодол	
Хөх тариа	5	т		Задгай өвс	20	т	
Бог будаа	6	т		Сүрэл	21	т	
4.2 Хүнсний ногоо				Гар тэжээл, зоодой	22	т	
Сонгино	7	кг		Хужир, шүү	23	т	
Сармис	8	кг		4.5 Жимс, жимсгэнэ			
Өргөст хэмх	9	кг		Чацаргана	24	кг	
Улаан лооль	10	кг		Үхрийн нүд	25	кг	
Тарвас	11	кг		Аньс	26	кг	
4.3 Тэжээлийн ургамал				Ранетка	27	кг	
Ногоон тэжээл	12	т		Нэрс	28	кг	
Олон наст	13	т		4.6 Хэрэглээний мод			
Даршны ургамал	14	т		Түлээний мод	29	м ³	
Бусад	15	т					

5. Хөдөө аж ахуйн бусад бүтээгдэхүүний үнэ

	Мөрийн дугаар	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ (төгрөг)		Мөрийн дугаар	Хэмжих нэгж	Үнэ (төгрөг)
А	Б	В	1	А	Б	В	1
Өндөг	1	ш		Аргал	7	тн	
Зөгийн бал	2	кг		Хөрзөн	8	тн	
Загас				Үнэгний арьс	9	ш	
цагаан загас	3	кг		Туулайны арьс	10	ш	
булуу цагаан/сазаан/	4	кг		Бугын цусан эвэр	11	кг	
бусад	5	кг		Бугын ясан эвэр	12	кг	
Тахианы өд	6	гр		Цаа бугын эвэр	13	кг	

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн мэдээний маягт нөхөх заавар

ХАА-н бүтээгдэхүүний үнийн мэдээнд импортын бүтээгдэхүүний үнэ судлагдахгүй, зөвхөн дотоодын бүтээгдэхүүний үнийг мэдээнд хамруулна.

Баг, хорооны Засаг дарга, сумын Засаг даргын орлогч, дүүргийн статистикийн хэлтэс нь мал, тэжээвэр амьтад, аргал, хөрзөн, газар тариалангийн зарим бүтээгдэхүүний үнийн мэдээг сум, дүүргийн (Багануур, Налайх) худалдааны зах, цэгээс сар бүрийн 28-ны өдөр ажиглалт хийж цуглуулна.

ХАА-н гаралтай түүхий эд, мах сүү, хүнсний ногооны үнийн мэдээг аймгийн төв, нийслэлийн түүхий эдийн (Эмээлт) болон хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийг мэдээг цуглуулж буй хүнсний зах, цэгээс аймаг, дүүргийн статистикийн хэлтэс сар бүрийн 28-ны өдөр ажиглалт хийж цуглуулна.

Үнийн мэдээнд хамруулах цэг, захыг хүн ам өргөнөөр үйлчлүүлж буй байдал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний борлогддог байршлыг харгалзан аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газар сонгоно. Мэдээнд аль болох тогтмол үйл ажиллагаатай цэгийг хамруулна.

ХАА-н бүтээгдэхүүний үнийг тухайн зах, цэгт худалдаж байгаа болон худалдан авч буй үнээр бүртгэнэ. Мөн тухайн төрлийн бүтээгдэхүүн нь үнийн мэдээ цуглуулах үед байхгүй байсан ч тухайн өдөр зарагдсан нэрлэсэн үнэ байгаа бол уг үнийг мэдээнд хамруулна. Хэрвээ тухайн бүтээгдэхүүн зарагдаагүй тухайн өдөр нэрлэсэн үнэ тогтоогүй бол үнийн мэдээнд хамаарахгүй.

Үнийн мэдээг цуглуулахдаа ХАА-н бүтээгдэхүүний үнийн мэдээнд хамруулах бүтээгдэхүүний зурагт каталогт заасан тодорхойлолтыг хатуу баримтлах бөгөөд тодорхойлолтыг хангахгүй, чанар муудсан, эсвэл эсгэж, гэмтснээс үнэ нь хямдарсан түүхий эд, бүтээгдэхүүний үнийг мэдээнд хамруулахгүй.

ХАА-н бүтээгдэхүүний үнийн мэдээг дараах төрлөөр цуглуулна. Үүнд: Малын үнэ, тэжээвэр амьтдын үнэ, малын гаралтай бүтээгдэхүүний үнэ, ХАА-н бусад бүтээгдэхүүний үнэ, газар тариалангийн бүтээгдэхүүн.

1. Малын үнэ. Малын үнийг баг, хорооноос цуглуулан, сум, дүүргийн дундаж үнийг тооцон, аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтэст хүргүүлэх бөгөөд аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтэс нь сум, дүүргээс ирүүлсэн үнийн мэдээнд үндэслэж аймаг, нийслэлийн дундаж үнийг тооцож ҮСХ-нд ирүүлнэ.

Малын үнийн мэдээнд хүнсний болон ашиг шим, уналга, эдэлгээний зориулалтаар амьдаар борлуулсан малын үнийг хамруулах бөгөөд харин шилмэл омгийн мах, сүүний чиглэлийн, хурдны морь зэрэг өндөр үнээр борлуулсан малын үнийг үнийн мэдээнд хамруулахгүй.

Малын үнэ нэг сарын дотор харьцангуй хэлбэлзэл бага байх хэдий ч улирлын онцлог болон цас, зуд, ган гамшиг зэрэг байгаль, цаг агаарын хүндрэлээс шалтгаалж малын үнэд гарсан хэлбэлзлийг үнийн мэдээнд бодитойгоор тусгаж, тайлбарыг бэлтгэн ирүүлнэ.

Малын үнийг малын төрөл тус бүрээр, малын нас, хүйсээр зурагт каталогт заасан тодорхойлолтын дагуу цуглуулна. Малыг дотор нь хээлтүүлэгч, нас гүйцсэн мал, өсвөр мал, төл мал гэж ангилна.

Нас гүйцсэн малд: тэмээний хувьд эр- нас гүйцсэн ат, эм- нас гүйцсэн ингэ; адууны хувьд эр -соёолон үрээ, эм-соёолон гүү; үхрийн хувьд эр-хязгаалан шар, эм-хязгаалан дөнж, хонины хувьд эр, эм хонь, ямааны хувьд эр, эм ямаа;

Өсвөр насны малд: тэмээний хувьд шилбэ буюу 3 настай эр, эм тэмээ; адууны хувьд: эр-шүдлэн үрээ, эм-шүдлэн байдас; үхрийн хувьд эр- шүдлэн үхэр; эм-шүдлэн гунж; хонины хувьд эр, эм төлөг, ямааны хувьд эр, эм борлон;

Төл малд: тухайн жилийн эр, эм ботго, унага, тугал, хурга, ишгийг тус тус хамруулна.

2. Тэжээвэр амьтдын үнэ. Гахай, тахиа, галуу, үнэг, илжиг, цаа буга, туулай, зөгий зэрэг ашиг олох зорилгоор өсгөн үржүүлж буй гэрийн тэжээвэр амьтдын үнийг судална.

Тэжээвэр амьтдын үнийн мэдээг баг, хорооноос багийн засаг дарга, сумын засаг даргын орлогч цуглуулж, тэдгээрийн сум, дүүргийн дундаж үнийг тооцон, аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтэст хүргүүлэх бөгөөд аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтэс нь сум, дүүргийн мэдээнд үндэслэж мөн аймаг, нийслэлийн дундаж үнийг тооцож ҮСХ-нд ирүүлнэ.

3. Малын гаралтай бүтээгдэхүүний үнэ. Малын гаралтай бүтээгдэхүүн болох зарим төрлийн мах, сүү, ноос, ноолуур, хөөвөр, хялгас, арьс, ширний үнийг аймаг, нийслэлийн төвлөрсөн захгаас цуглуулж, аймаг, нийслэлийн дундаж үнийг ҮСХ-нд ирүүлнэ.

Мах, сүүний үнийн мэдээнд хэрэглээний барааны бүтээгдэхүүний үнийн мэдээнд хамрагдаагүй бүтээгдэхүүний үнийг цуглуулахаар тусгасан.

Сүүний үнийн мэдээг ингэний, гүүний, хонь, ямааны буюу богийн сүү гэсэн ангиллаар хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн мэдээллийг цуглуулж буй зах, цэгээс цуглуулна.

Үхрийн ширний үнийн мэдээг 1.8-2.3 метрийн хэмжээтэй; 2.3 метрээс дээш (үйлдвэрийн стандарт) хэмжээтэй гэсэн хоёр ангиллаар цуглуулах бөгөөд ширний хэмжээг тодорхойлохдоо ширний толгойн хэсгийн ухлаадаснаас сүүлний хэсгийн ухлаадасны хоорондох уртаар хэмжинэ.

Адууны ширний үнийн мэдээнд зөвхөн нас гүйцсэн малын ширний үнийн мэдээллийг хамруулна.

Хонь, ямааны арьсны үнэд өлөн гэдэсний үнэ орохгүй. Хонины арьсыг ноостой, ноосгүй; ямааны арьсыг ноолууртай, ноолуургүй гэсэн ангиллаар цуглуулна. Хонины ноосгүй нэхий, ямааны ноолуургүй арьс нь ихэвчлэн 6-7 сар, хонины ноостой нэхий, ямааны ноолууртай арьс нь гол төлөв 1-5, 8-12 сард түүхий эдийн зах зээлд борлуулагддагийг анхаарвал зохино. Бог малын арьсны үнийн мэдээнд хурга, ишигний арьсны үнийн мэдээллийг хамруулахгүй бөгөөд төлийн арьсны үнийн мэдээг тусад нь бүртгэнэ.

4. Газар тариалангийн бүтээгдэхүүний үнэ. Үр тариа, тэжээлийн ургамал, техникийн ургамал, жимс, жимсгэнэ, түлээ, түлшний үнийг сум, дүүргээс, хүнсний ногоо болон тарвас, үндэст, булцуут ногоо (сонгино, сармис гэх мэт)-ны үнийг аймаг, нийслэлийн төвлөрсөн зах, цэгээс цуглуулж, дундаж үнийг ҮСХ-нд ирүүлнэ.

Үнийн мэдээнд хамрагдах дээрх бүтээгдэхүүн нь импортын биш, дотооддоо тарьж, ургуулсан бүтээгдэхүүн байхыг анхаарна.

Маягтанд тусгагдаагүй хүнсний бусад ногооны хувьд хэрэглээний барааны сагсанд багтдаг тул ХАА-н үнийн мэдээнд хамруулахгүй.

Маягтанд тусгасан хүнсний ногооны үнийн мэдээллийг хэрэглээний үнийн мэдээлэлд хамрагдаж буй зах, цэгээс цуглуулна.

Бэлтгэсэн өвсний үнийг задгай өвс, боодолтой (преслэсэн, дунджаар 25 кг) өвс гэж салгаж авна.

Хэрэглээний модны үнийг цуглуулахдаа м³-ээр хэмжиж авна.

5. Хөдөө аж ахуйн бусад бүтээгдэхүүний үнэ. Өндөг, зөгийн бал, загас, тахианы өд, үнэг, туулайны арьс, бугын цусан ба ясан эвэр, цаа бугын эвэр, аргал, хөрзөн зэрэг бүтээгдэхүүнийг хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд хамруулан тэдгээрийн үнийг аймаг, нийслэлийн төвлөрсөн зах, сум, дүүргээс үнийн зурагт каталогт заасан тодорхойлолтын дагуу цуглуулан нэгтгэж, дундаж үнийг ҮСХ-нд ирүүлнэ.

Өндөг, зөгийн бал, загас нь дотоодын бүтээгдэхүүн байх бөгөөд импортоор оруулж ирсэн бүтээгдэхүүний үнийг мэдээнд хамруулахгүй байхыг анхаарна. Загас нь цагаан загас, булуу цагаан буюу сазаан загас байна. Бусад гэдэгт эдгээр нэр төрлөөс бусад нэр төрлийн загасыг хамруулна.

ХАА-н гаралтай бүтээгдэхүүнээс аргал, хөрзөнгийн үнийг сум, дүүргээс авч, аймаг, нийслэлийн дундаж үнийг тооцон ҮСХ-нд ирүүлнэ.

Үндэсний статистикийн хороо

Утас: 261559, 323152